



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/34


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай 29/31 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Захирамжид өөрчлөлт оруулах тухай" А/1303, 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1303 захирамжаар батлагдсан Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны "3 дугаар 27 болон 3 дугаар 30 айлын орон сууцны дээврийн засвар"-ын ажил, 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих хот тохижилт, нийтийн аж ахуй, барилга засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалтын 84 дүгээр ажлын гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, гэрээ байгуулах зөвлөмжийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Т.Хэрлэн/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 04 сарын 03 өдрийн
... тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|----------------------|--------------|--|
| Дарга | Т.Хэрлэн | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга |
| Гишүүд | Э.Уянга | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Л.Баатарцогт | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Н.Энхбат | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Чоймболын 55-64 тоот иргэн /зөвшилцсөнөөр/ |
| Нарийн бичгийн дарга | О.Батмөнх | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн |